

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Галшар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2026/171/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

Audit.mn

Хэнтий аймаг

Чингис хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан  
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа  
Утас: 99088151 мэйл хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.24 № 264

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1.8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Галшар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангилал бүрээр бус “бараа үйлчилгээний бусад зардал” ангилалд нэгтгэн төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар 3,542.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 233.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,171.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,136.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүллээ.

**Бусад асуудал**

Хэнтий аймгийн Галшар сумын Хүүхдийн цэцэрлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 5 зорилтын хүрээнд 59 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 70.4 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>152,744,126.25</u></b>	<b><u>124,242,682.47</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	88,220,443.95	55,427,395.03
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	88,220,443.95	55,427,395.03
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	88,220,443.95	55,427,395.03
31211	Төрийн сангийн харилцах	88,220,443.95	55,427,395.03
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	92,300.14
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	92,300.14
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	64,523,682.30	68,722,987.30
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	64,523,682.30	68,722,987.30
35410	Бичиг хэргийн материал	3,466,580.00	6,835,480.00
35420	Аж ахуйн материал	41,460,870.00	37,392,391.60
35440	Түлш, шатах тослох материал	262,000.00	-
35460	Хүнсний материал	5,589,396.30	4,525,280.70
35470	Бусад хангамжийн материал	13,744,836.00	19,969,835.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>407,773,914.57</u></b>	<b><u>406,458,349.95</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	407,773,914.57	406,458,349.95
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	401,683,914.57	400,368,349.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	472,472,842.00	462,417,442.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(160,499,278.29)	(170,179,843.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,363,140.00	57,196,240.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,874,447.43)	(14,538,011.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,729,167.00	80,584,567.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,772,463.36)	(16,376,998.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,264,954.65	1,264,954.65
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,090,000.00	6,090,000.00
39301	Програм хангамж	67,000.00	67,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(67,000.00)	(67,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,090,000.00	6,090,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>560,518,040.82</u></b>	<b><u>530,701,032.42</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>560,518,040.82</u></b>	<b><u>530,701,032.42</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	560,518,040.82	530,701,032.42
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	32,819,075.00	32,819,075.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	462,574,450.69	432,757,442.29
51210	Өмнөх үеийн үр дүн	462,574,450.69	462,574,450.69
51220	Тайлант үеийн үр дүн	-	(29,817,008.40)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	65,124,515.13	65,124,515.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>560,518,040.82</u></b>	<b><u>530,701,032.42</u></b>

Хэнтий аймгийн Галшар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>421,992,700.00</b>	<b>512,758,437.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>42,000.00</b>	<b>44,561,337.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	42,000.00	44,561,337.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,000.00	231,337.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,000.00	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	231,337.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	0.0	34,500,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	0.0	9,830,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	0.0	<b>468,197,100.00</b>
1221	Тусламжийн орлого	0.0	404,807,100.00
12211	Хандив тусламж /дотоод/	0.0	404,807,100.00
122111	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	404,807,100.00
122111	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	63,390,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>421,950,700.00</b>	0.0
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	360,906,800.00	0.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	360,906,800.00	0.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	61,043,900.00	0.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,043,900.00	0.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>431,813,888.25</b>	<b>542,575,445.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>431,813,888.25</b>	<b>542,575,445.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	427,526,729.48	536,690,609.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	273,061,869.00	353,113,088.04
210101	Үндсэн цалин	194,968,639.00	226,950,785.00
210102	Нэмэгдэл	69,453,930.00	101,171,173.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,165,000.00
210104	Урамшуулал	8,639,300.00	16,826,130.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,858,401.06	44,403,947.74
210201	Тэтгэврийн даатгал	26,248,618.25	30,491,097.31
210202	Тэтгэмжийн даатгал	2,641,919.54	3,476,844.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,311,059.87	1,738,422.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,311,059.87	1,708,084.55
210205	Эрүүл мэндийн даатгал	5,345,743.53	6,989,499.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	37,758,441.23	40,306,164.43
210301	Гэрэл, цахилгаан	2,385,030.53	3,767,554.49

Хэнтий аймгийн Галшар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	35,273,410.70	35,573,609.94
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	965,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>26,276,452.70</b>	<b>27,957,265.60</b>
210502	Хоол, хүнс	26,276,452.70	27,957,265.60
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>8,316,650.00</b>
210604	Урсгал засвар	-	8,316,650.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>944,200.00</b>	<b>893,500.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	944,200.00	893,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>52,627,365.49</b>	<b>61,699,994.02</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,023,208.00	23,981,929.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	374,700.00	1,902,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,229,457.49	35,815,564.62
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,287,158.77</b>	<b>5,884,835.57</b>
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.0	5,884,835.57
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>4,287,158.77</b>	<b>0.0</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,287,158.77	0.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(9,821,188.25)</b>	<b>(29,817,008.40)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,252,455.48</b>	<b>0.0</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,252,455.48	0.0
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(1,252,455.48)</b>	<b>0.0</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(11,073,643.73)</b>	<b>(29,817,008.40)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>421,992,700.00</u></b>	<b><u>468,428,437.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>42,000.00</b>	<b>468,428,437.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>42,000.00</b>	<b>231,337.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	42,000.00	231,337.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,000.00	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	231,337.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>0.0</b>	<b>468,197,100.00</b>
1221	Хандив тусламж /дотоод/	0.0	404,807,100.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	404,807,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	0.0	404,807,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	0.0	63,390,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>421,950,700.00</b>	<b>0.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>360,906,800.00</b>	<b>0.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	360,906,800.00	0.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>61,043,900.00</b>	<b>0.0</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,043,900.00	0.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>412,834,780.06</u></b>	<b><u>501,221,485.92</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>412,834,780.06</b>	<b>501,221,485.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>408,547,621.29</b>	<b>495,336,650.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>276,422,800.31</b>	<b>356,447,806.44</b>
210101	Үндсэн цалин	188,918,176.31	209,554,964.92
210102	Нэмэгдэл	78,943,732.00	122,754,196.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,075,000.00
210104	Урамшуулал	8,560,892.00	16,063,645.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,497,469.75</b>	<b>41,161,529.48</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,887,686.94	28,196,133.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,641,919.44	3,238,564.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,311,059.87	1,619,305.72
210204	Ажилгүйдлийн даатгал	1,311,059.87	1,594,492.97
210205	Эрүүл мэндийн даатгал	5,345,743.63	6,513,033.20
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,758,441.23</b>	<b>40,306,164.43</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,385,030.53	3,767,554.49
210302	Түлш, халаалт	35,273,410.70	35,573,609.94
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	965,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,341,940.00</b>	<b>26,893,150.00</b>
210502	Хоол, хүнс	24,341,940.00	26,893,150.00

Хэнтий аймгийн Галшар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,998,300.00</b>	<b>17,199,000.00</b>
210604	Урсгал засвар	18,998,300.00	17,199,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>944,200.00</b>	<b>893,500.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	944,200.00	893,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,584,470.00</b>	<b>12,435,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,382,270.00	9,890,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,202,200.00	2,545,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,287,158.77</b>	<b>5,884,835.57</b>
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.0	5,884,835.57
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>4,287,158.77</b>	<b>0.0</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,287,158.77	0.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>9,157,919.94</u></b>	<b><u>(32,793,048.92)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>9,157,919.94</b>	<b>(32,793,048.92)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>79,062,524.01</b>	<b>88,220,443.95</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>88,220,443.95</b>	<b>55,427,395.03</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>32,819,075.00</b>	<b>65,124,515.13</b>	<b>462,574,450.69</b>	<b>560,518,040.82</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>32,819,075.00</b>	<b>65,124,515.13</b>	<b>462,574,450.69</b>	<b>560,518,040.82</b>
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
10	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>32,819,075.00</b>	<b>65,124,515.13</b>	<b>462,574,450.69</b>	<b>560,518,040.82</b>
11	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>32,819,075.00</b>	<b>65,124,515.13</b>	<b>462,574,450.69</b>	<b>560,518,040.82</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>32,819,075.00</b>	<b>65,124,515.13</b>	<b>462,574,450.69</b>	<b>560,518,040.82</b>
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(29,817,008.40)	(29,817,008.40)
20	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>32,819,075.00</b>	<b>65,124,515.13</b>	<b>432,757,442.29</b>	<b>530,701,032.42</b>

Хэнтий аймгийн Галшар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>544,307,800.00</b>	<b>462,543,601.43</b>	<b>(81,764,198.57)</b>	<b>85.0</b>
<b>12</b>	Татварын бус орлого	<b>544,307,800.00</b>	<b>462,543,601.43</b>	<b>(81,764,198.57)</b>	<b>85.0</b>
<b>120</b>	Нийтлэг татварын бус орлого	<b>231,400.00</b>	<b>231,337.00</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
<b>120010</b>	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	231,400.00	231,337.00	0.0	100.0
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	<b>473,526,800.00</b>	<b>404,807,100.00</b>	<b>(70,836,063.00)</b>	<b>85.1</b>
122111	Урсгал санхүүжилтийн орлого	405,093,500.00	404,807,100.00	(70,836,063.00)	85.1
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	<b>68,433,300.00</b>	<b>57,505,164.43</b>	<b>(10,928,135.57)</b>	<b>84.0</b>
122111	Урсгал санхүүжилтийн орлого	68,433,300.00	57,505,164.43	(10,928,135.57)	84.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>544,307,800.00</b>	<b>495,336,650.35</b>	<b>(48,971,149.65)</b>	<b>91.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>544,307,800.00</b>	<b>495,336,650.35</b>	<b>(48,971,149.65)</b>	<b>91.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>544,307,800.00</b>	<b>495,336,650.35</b>	<b>(48,971,149.65)</b>	<b>91.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>386,613,500.00</b>	<b>356,447,806.44</b>	<b>(30,165,693.56)</b>	<b>92.2</b>
210101	Үндсэн цалин	230,690,600.00	209,554,964.92	(21,135,635.08)	90.8
210102	Нэмэгдэл	142,298,800.00	122,754,196.52	(19,544,603.48)	86.3
210104	Урамшуулал	13,624,100.00	16,063,645.00	2,439,545.00	117.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,066,400.00</b>	<b>41,161,529.48</b>	<b>(6,904,870.52)</b>	<b>85.6</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,602,000.00	28,196,133.01	(4,405,866.99)	86.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,866,100.00	3,238,564.58	(627,535.42)	83.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,933,000.00	1,619,305.72	(313,694.28)	83.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,933,000.00	1,594,492.97	(338,507.03)	82.5
210205	Эрүүл мэндийн даатгал	7,732,300.00	6,513,033.20	(1,219,266.80)	84.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>53,433,300.00</b>	<b>40,306,164.43</b>	<b>(13,127,135.57)</b>	<b>75.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,166,000.00	3,767,554.49	(6,398,445.51)	37.1
210302	Түлш, халаалт	42,067,300.00	35,573,609.94	(6,493,690.06)	84.6
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	965,000.00	(235,000.00)	80.4
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>27,186,700.00</b>	<b>26,893,150.00</b>	<b>(293,550.00)</b>	<b>98.9</b>
210502	Хоол, хүнс	27,186,700.00	26,893,150.00	(293,550.00)	98.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,000,000.00</b>	<b>17,199,000.00</b>	<b>2,199,000.00</b>	<b>114.7</b>
210604	Урсгал засвар	15,000,000.00	17,199,000.00	2,199,000.00	114.7
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,489,300.00</b>	<b>893,500.00</b>	<b>(595,800.00)</b>	<b>60.0</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,489,300.00	893,500.00	(595,800.00)	60.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,518,600.00</b>	<b>12,435,500.00</b>	<b>(83,100.00)</b>	<b>99.3</b>

Хэнтий аймгийн Галшар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,970,200.00	9,890,000.00	(80,200.00)	99.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,548,400.00	2,545,500.00	(2,900.00)	99.9
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(70,549,600.00)</b>	<b>(32,793,048.92)</b>	<b>(32,883,048.92)</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ НӨХӨХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>70,549,600.00</b>	<b>32,793,048.92</b>	<b>32,883,048.92</b>	<b>-</b>
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	<b>70,549,600.00</b>	32,793,048.92	32,883,048.92	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>88,220,443.95</b>	<b>88,220,443.95</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>55,427,395.03</b>	<b>55,427,395.03</b>	<b>-</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0.0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>17</b>	<b>14</b>	<b>(3)</b>	<b>82.4</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8	5	(3)	62.5

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,542.0 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 233.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 3,308.2 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд буруу бүртгэсэн, хүн амын орлогын албан татварын тайланг зөрүүтэй тайлагнасан 2 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,542.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Ур чадварын нэмэгдлийг хагас жил тутамд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, нотлох баримтгүй, амжилтын түвшний хувийг 2 ажилтанд илүү тооцож 233.8 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь "Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх**

#### 3.2 Албан шаардлага

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, аудитын дүгнэлт өөрчлөлтгүй, 2024 оны төлөвлөгөөний биелэлт 97.0 хувиар үнэлэгдсэн үзүүлэлтээр цэцэрлэгийн эрхлэгчид 20 хувиар тооцож ур чадварын нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь "Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн, Биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх**

2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.1-д "бие даасан байх", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 15.2- т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн Биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх**

3. Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоог бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12 дугаар зүйлийн 12.2.2 дахь

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заалт "Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ." заалт, 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн, Биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх**

#### **3.3 Зөвлөмж**

##### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт-1:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 13 нэр төрлийн (анхны өртөг 10,675.0 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1."Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж, шийдвэрлүүлэх

##### **2. Татварын бүртгэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт-1:** Цалингийн журналын дүнг татвар, нийгмийн даатгалын тайлантай тулган шалгахад хувь хүний орлогын албан татварын тайланг 1,136.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20.2.7 "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварын тооцоог дахин хийх, тооцоо нийлж баталгаажуулах, цаашид зөрчлийг дахин гаргахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг хагас жил дутамд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, нотлох баримтгүй, амжилтын түвшний хувийг 2 ажилтанд илүү тооцож төгрөг олгосон	1	233.8	1	233.8								
Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, аудитын дүгнэлт өөрчлөлтгүй, 2024 оны төлөвлөгөөний биелэлт 97.0 хувиар үнэлэгдсэн үзүүлэлтээр цэцэрлэгийн эрхлэгчид 20 хувиар тооцож ур чадварын нэмэгдэл олгосон	1	2,171.4			1	2,171.4						
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй	1				1	-						
айгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооллогын бүртгэл хөтөлсөн боловч тооцоог бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй	1	-			1							
10,675.0 мянган төгрөгийн 13 нэр төрлийн үндсэн хөрөнгийг	1	-					1	-				

Хэнтий аймгийн Галшар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

бараа материалын дансанд буруу бүртгэсэн												
Цалингийн журналын дүнг татвар, нийгмийн даатгалын тайлантай тулган шалгахад хувь хүний орлогын албан таварын тайланг 1,136.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан	1						1	1,136.7				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>3,542.0</b>	<b>1</b>	<b>540.8</b>	<b>3</b>	<b>2,171.4</b>	<b>2</b>	<b>1,136.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
<b>Дүн</b>												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
<b>Дүн</b>												
<b>Нийт дүн</b>												